УВС АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

УВС АЙМАГ
2012 ОНД

Улаангом хот

АГУУЛГА

Аргачлалын тайлбар 4

I. Нийгмийн үзүүлэлт

1.1 Хүн ам 6

1.2 Өрх, өрхийн зарим үзүүлэлт 7

1.3 Нийгмийн даатгал, халамж,нөхөн олговор 7

1.4 Ажилгүй иргэд 8

1.5 Эрүүл мэнд 9

1.6 Боловсрол 10

1.7 Соёл 10

1.8 Гэмт хэрэг 11

II. Макро эдийн засгийн үзүүлэлт

2.1 Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 13

2.2 Мөнгө зээл 14

2.3 Орон нутгийн төсвийн орлого 15

2.4 Орон нутгийн төсвийн зарлага 16

2.5 Орон нутгийн төсвийн өглөг,авлага 16

2.6 Гадаад худалдаа 17

2.7 Дотоод худалдаа 17

III. Эдийн засгийн салбарын үзүүлэлт

3.1 Аж үйлдвэр 18

3.2 Барилга 19

3.4 Хөдөө аж ахуй

3.4.1 Мал аж ахуй

Малын тоо 20

Хээлтэгч мал 21

Амины малын бүлэглэлт 21

Төллөлт, төл бойжилт 22

Том малын зүй бусын хорогдол 22

Шинээр гаргасан ба засварласан худаг 22

Малжуулалт 22

3.5 Газар тариалан

Тариалалт 23

Ургац хураалт 23

3.6 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дундаж үнэ 23

3.7 Тээвэр холбоо 24

3.8 Цаг уурын байдал 24

Хүснэгтэн мэдээллүүд

Аймгийн үндсэн үзүүлэлт 25-28

Багийн өрх, хүн ам , малын тоо 29-30

Аймгийн төв, сум хоорондын замын урт 31

Хүн амын үзүүлэлтүүд 31-47

Ажиллах хүч 48-52

Дотоодын нийт бүтээгдэхүүн 52-53

Хэрэглээний үнийн индекс 54-55

Мөнгө санхүү 56-58

Орон нутгийн төсөв даатгал 59-65

Барилга 66-68

Хөдөө аж ахуй 69-89

Аж үйлдвэр 90-94

Тээвэр холбоо 95-96

Гадаад худалдаа 97-98

Зочид буудал зоогийн газар 98

Орон сууц нийтийн аж ахуй 98-100

Өрхийн орлого, зарлага, хүн амын амьжиргааны доод түвшин, ядуурал 100-101

Боловсрол, соёл урлаг, спорт 101-106

Хүн амын эрүүл мэнд 107-111

Гэмт хэрэг 112-114

Байгаль орчин 114

Бизнес регистрийн сан 115-118

Хүний хөгжлийн индекс 119

Хэрэглэгчдэд зориулсан гарын авлага 120

Аргачлалын тайлбар:

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Төсвийн орлого зарлагын тооцоог Олон улсын Валютын сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн гаргаж байна. Төсвийн орлогын мэдээг аймгийн Татварын хэлтэс, төсвийн зарлага, санхүүжилтийн мэдээг СЭЗТС-ийн хэлтсээс гаргадаг.

Төсвийн орлогын мэдээг хэрэглэгчдэд илүү тодорхой болгох зорилгоор аймгийн нийт төсвийн орлого, үүнээс улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, орон нутгийн төсвийн орлого, үүнээс улсын төсөвт /аймгийн/ төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт гэж салгаж харууллаа.

Төсвийн зарлагыг эдийн засгийн салбарын ангиллаар гаргаж, улсын төсвийн байгууллагууд, орон нутгийн төсвийн байгууллагууд гэж тус тусдаа гарсныг нэгтгэж орууллаа.

ҮНЭ

Аймгийн төвийн хүнсний зах дээр борлогдож байгаа хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдхүүн, ноос, ноолуур, арьс шир зэрэг зарим бүтээгдхүүний зах зээлийн дундаж үнийг харуулав.

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан,үйлчлүүлсэн хамгийн чухал, эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

2012 оноос эхлэн хэрэглээний сагсны нэр төрлийг шинэчилж 213 нэр төрөл болгож 2010 оны 12-р сарын үнээр суурилан ХҮИ-ийг тооцож байна.

АЖ ҮЙЛДВЭР

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдхүүний өсөлтийг гол нэр төрлийн бүтээгдхүүнийг 2005 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Гол нэр төрлийн бүтээгдхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

ХӨДӨЛМӨР

Ажилгүйчүүдийн тоонд олон улсын стандарт ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, нөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орно.

ЭРҮҮЛ МЭНД

Нялхсын нас баралт (1 хүртэл насны 1000 хүүхдэд ногдох) –ыг тухайн үед 1 хүртэлх насны нас барсан хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

ГЭМТ ХЭРЭГ

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог жилийн дундаж 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно

ХАА-н САЛБАР

Аймгийн ИТХ-ын 2002 оны ээлжит 8-р хуралдаанаар баталсан бүсүүд:

Баруун бүс : Завхан, Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Тариалан, Ховд

Хойт бүс : Бөхмөрөн, Давст, Сагил, Түргэн

Зүүн бүс: Зүүнговь, Малчин, Тэс, Хяргас

Өмнөт бүс:Баруунтуруун, Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан

Төвийн бүс : Улаангом хот

ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ТАЛБАР :

1. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III , IV, V..... г.м)

I-XII жилийн эхний тухайн сарыг оруулсан өсөн нэмэгдэх дүнг харуулав.

2. Дараахь тэмдэглэлүүдийг ашиглав :

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

- гүйцэтгэл байхгүй

Д - дахин

3. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрөх тохиолдол байж болно.

1. НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.1 Хүн ам

Энэ онд 2041 эхээс 2045 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс төрсөн хүүхдийн тоо 81 – ээр буюу 4.1 хувиар нэмэгдсэн байна.

Гэрийн төрөлт 9 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 4 төрөлтөөр цөөн байна.

Хүн амын төрөлт 2045 байгаа нь өмнөх 4 жилийн дунджаас 4.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүн амын нас баралт 480 гарч 1000 хүнд ноогдох 6.45 ноогдох болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 6.7 хувиар буюу 1000 хүнд ноогдох нь 0.4 пунктээр өндөр байна.

2012 онд 1000 хүн амд ноогдох цэвэр өсөлт 21.1 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0.8 пунктээр өсч, өмнөх 4 жилийн дунджаас 0.5 пунктээр буурсан үзүүлэлттэй байна

Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээс үндэслэн гаргасан хүн амын урьдчилсэн тоогоор 2012 оны эцэст 36977 эрэгтэй, 37049 эмэгтэй нийт 74026 хүн ам байнгын буюу 6 сараас дээш хугацаагаар суурин амьдарч байна. 2011 оноос хүн амын тоо 0.57 хувиар буюу 422 хүнээр буурсан байна.

Малчин, Зүүнговь, Өмнөговь, Завхан, Өлгий, Улаангом, Ховд, Өндөрхангай, Давст сумдын суурин хүн ам өнгөрсөн оноос 0.2 – 5.3 хувиар өсч, бусад сумдын хүн амын тоо 0.4 – 8,9 хувиар буурсан байна.

Хүйсийн харьцаа 99.8 хувь, 100 эмэгтэйд 100 эрэгтэй ноогдож байна.

Хүн амын 33.9 хувь нь буюу 25.1 мянга нь аймгийн төв суурин газарт, 19.6 хувь буюу 14.5 мянга нь сумын төвд, 46.5 хувь буюу 34.4 мянга нь хөдөөд амьдарч байна.



Хүн амын насыг 2012 оны 12-р сарын 31-тэй харьцуулж бүтэн насаар бодсоноор 33.6 хувийг г / 24.9 мянга / 0-14 насны хүүхэд, 61.1 хувийг / 45.2 мянга / хөдөлмөрийн насны хүн ам, 5.3 хувийг / 3.9 мянга / хөдөлмөрийн нас хэтэрсэн хүмүүс эзэлж 2011 онтой харьцуулахад хүүхдийн эзлэх хувь 0.4 пунктээр, хөдөлмөрийн нас хэтэрсэн хүний эзлэх хувь 0.01 пунктээр тус тус буурч, хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь 0.4 пунктээр нэмэгдсэн байна.

Хүн амын насыг 2012 оны 12 сарын 31-тэй харьцуулж бүтэн насаар бодсон бөгөөд 70 ба түүнээс дээш насны 1698 хүн, үүний 1049 нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд 100-аас дээш нэсны эмэгтэй 1 хүн Баруунтуруун суманд амьдарч байна.

19844 өрх байгаа нь өнгөрсөн оноос 0.2 хувиар буюу 45 өрхөөр өссөн. Нэг өрхөд дунджаар 3.7 хүн амьдарч байна.

1.2 Өрх, өрхийн зарим үзүүлэлт

Бүтэн өнчин хүүхэд 115, хагас өнчин хүүхэд 1659, өрх толгойлсон хүн 3841 байна. Өнгөрсөн онтой харьцуулахад бүтэн өнчин хүүхдийн тоо 1.8 хувиар, өрх толгойлсон хүний тоо 16.4 хувиар тус тус өсч, хагас өнчин хүүхдийн тоо 15.3 хувиар буурсан байна.

8-аас дээш ам бүлтэй 349 өрх, 16 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй 1836 өрх байгаа бөгөөд өнгөрсөн оноос 8-аас дээш ам бүлтэй өрхийн тоо 29.8 хувиар буурч, 16 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо 5.0 хувиар өссөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй 2854 хүн бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 2.8 хувиар өсчээ. Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүнээс 1280 эмэгтэй байгаа бөгөөд 44.8 хувийг эзэлж байна. Сүүлийн 4 жилийн дунджаас 133 иргэнээр буюу 4.9 хувиар өссөн байна.

1.3 Нийгмийн даатгал,халамж, нөхөн олговор

НДС-д шимтгэлээр 9576.1 сая төгрөг оруулахаас 9599.8 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 100.2 хувиар биелүүлж, 23.7 сая төгрөгөөр давууллаа. 2011 онтой харьцуулахад НДШ-ийн орлого 2578.7 сая төгрөгөөр буюу 36.7 хувиар өссөн байна.

Сангуудаар авч үзвэл орлогын төлөвлөгөөг тэтгэмжийн даатгалын сангийн орлого 4.2 хувиар,

тэтгэврийн даатгалын сангийн орлого 0.1 хувиар тус тус давуулан биелүүлж бусад сангууд даатгалын сангийн орлогыг 100 хувь биелүүлсэн байна.

НДС-ийн шимтгэлийн төлөвлөгөөг Баруунтуруун, Бөхмөрөн, Давст, Зүүнхангай, Тариалан, Түргэн, Улаангом сумууд 0.6 - 4.1 хувиар давуулан биелүүлж, бусад сумууд 0.5 - 6.0 хувиар тасалсан байна.

Сангуудаар авч үзвэл 2011 оноос тэтгэврийн даатгалын орлого 42.2 хувиар, ЭМД-н сангийн орлого 21.0 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 49.3 хувиар, ажилгүйдлийн

даатгалын сангийн орлого 44.0 хувиар, ҮОМШӨ-н сангийн орлого 37.2 хувиар тус тус өссөн байна.

17.2 тэрбум төгрөг тэтгэвэрт, 2214.4 сая төгрөг ЭМД-ын санхүүжилтэнд зориулан зарцуулж тэтгэвэр тэтгэмжийг бүрэн олгосон байна.

НДС 49.2 сая төгрөгийн авлагтай байгаа бөгөөд өнгөрсөн оноос 5.4 сая төгрөгөөр буюу 12.3 хувиар өссөн байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас 835.1 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 95.2 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 75.1 сая төгрөг, нийтдээ даатгалын сангуудаас 20.4 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд өнгөрсөн оноос 6974.1 сая төгрөгөөр буюу 51.8 хувиар өссөн байна.

Нийгмийн даатгалд 2012 онд 69,6 мянган хүн хамрагдсан нь 2011 оныхоос 3.0 мянган хүнээр буюу 4.1 хувиар буурсан байна.

8.0 мянган хүн тэтгэвэрт, 2.6 мянган хүн тэтгэмжинд хамрагдаж 1 хүнд дунджаар сард 179.0 мянган төгрөгийн тэтгэвэр, 27.2 мянган төгрөгийн тэтгэмж ноогдож өнгөрсөн оноос тэтгэвэр 64.9 мянган төгрөгөөр, тэтгэмж 6.4 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийгмийн халамжийн сангаас 2012 онд 22.9 мянган хүнд 5.9 тэрбум төгрөг зарцуулснаас халамжийн тэтгэвэрт 1872 хүнд 2163.5 сая, нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 1382 хүнд 784.1 сая төгрөг, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт 169.5 сая, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламжинд 629.8 сая, улсын төсвөөс олгосон тэтгэмж, тусламжинд / жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, алдар цолтой ахмадуудд, алдарт эхийн одонгийн / 2224.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Асрамжийн газар нийт 18 хүн асруулж байгаа бөгөөд 13 эмэгтэй, 5 хүүхэд байна. Асрамжийн үйд ажиллагаанд нийт 266.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

1 хүнд 1912.0 мянган төгрөгийн нөхөн олговор олгогдсон байна.

1.4 АЖИЛГҮЙДЭЛ

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй хүний тоо 1002 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.3 дахин буюу 561 хүнээр өссөн байна. Аймгийн хэмжээнд 577 эмэгтэй ажил идэвхитэй эрж байгаа нь ажилгүйчүүдийн 57.6 хувийг эзэлж байна.

Энэ онд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо өмнөх 4 жилийн дунджаас 24.7 хувиар буюу 329 ажилгүйчүүдээр буурсан байна.

Ажилгүйчүүдийн 23.3 хувь нь дээд, 10.1 хувь нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 59.3 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой, 7.3 хувь нь бага болон боловсролгүй хүмүүс эзэлж байна.

16 дээш насны арван мянган хүнд 211 ажилгүйчүүд ноогдож байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2.3 дахин өссөн байна.

Өлгий, Улаангом сумуудад арван мянган хүнд 233- 336 ажилгүйчүүд ногдож байгаа нь аймгийн дунджаас 22-125 пунктээр дээгүүр байгаа бөгөөд бусад сумдууд 8 -135 пунктээр доогуур байна.

1.5 ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд 2012 онд нэг хүртэлх насандаа 31 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 15 хүүхдээр цөөн, 1 – 5 хүртэлхи насны 9 хүүхэд эндэж өмнөх оны мөн үеийнхээс 1 хүүхдээр цөөн байна.

Жирэмслэлт болон төрөлтийн улмаас эхийн эндэгдэл гараагүй байна.

5 хүртэлх насны хүүхдийн эндэглийн түвшин Наранбулагт 210.5, Давст суманд 200, Түргэнд 100, Сагилд 95.2, Цагаанхайрханд 66.7, Малчинд 52.6, Бөхмөрөнд 45.5, Зүүнхангайд 38.5, Завханд 37, Өмнөговьд 36.6, Ховд суманд 33.3 байгаа нь аймгийн дунджаас 13.7 – 190.9 промилээр өндөр, Улаангом, Өндөрхангай, Тариалан сумдууд аймгийн дунджаас 1.4 – 5.4 промилээр бага, бусад сумдад гараагүй байна.

0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 31 гарч нялхсын эндэгдлийн түвшин 15.2 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс гаралт 15 – аар, 1000 амьд төрөлтөд ноогдох эндэгдэл 8.3 промилээр буурсан байна. Өмнөх 4 жилийн дунджаас нялхсын эндэгдлийн түвшин 12.2 промилээр, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 13.8 промилээр тус тус буурсан байна.

Нялхсын эндэгдлийн түвшин Давст, Цагаанхайрхан, Малчин, Наранбулаг, Бөхмөрөн, Зүүнхангай, Завхан, Өмнөговь, Ховд, Тариалан, Өндөрхангай сумдад аймгийн дунджаас 1.5 – 184.8 промилээр өндөр, Улаангом суманд аймгийн дунджаас 3 промилээр бага бусад сумдад гараагүй байна.

Нийт нас баралтын 18.9 хувийг эмнэлэгийн нас баралт эзэлж өнгөрсөн оны мөн үеэс 1.7 пунктээр буурсан байна.

Осол гэмтлийн улмаас 58 хүн нас барж, өвчлөгчдийн тоо 595 байна. Осол гэмтлийн улмаас нас барагчдын тоо өмнөх 3 жилийн дунджаас 1.2 хувиар өсч, өвчлөгчдийн тоо 25.9 хувиар бага байна.

Хорт хавдраар өвчлөгчдийн тоо 135 болж, 151 хүн нас барсан байна. Хорт хавдраар өвчлөгсдийн тоо өмнөх 3 жилийн дунджаас 10 хувиар буурч , нас барагсдын тоо 5.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 663 болж өнгөрсөн оны мөн үеэс 46.4 хувиар буюу 575 гаралтаар буурсан байна. Мөн үеийн халдварт өвчний гаралт өмнөх 4 жилийн дунджаас 32 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнийг хувиар авч үзвэл гепатит өвчин өмнөх оны мөн үед нийт халдварт өвчний 65.8 хувийг эзэлж байсан бол энэ оны байдлаар 30.8 хувиар буурч, харин БЗХӨ 17.9, салхинцэцэг 3.6 хувиар тус тус өссөн байна.

Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 35.0 хувь нь гепатит, 32.7 хувь нь БЗХӨ, 7.7 хувь нь сүрьегээр 5.6 хувь нь мөөгөнцөрөөр, 0.9 хувь нь гахайн хавдар, 18.1 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилжээ.

Өнгөрсөн оны мөн үеэс трихоманиаз 25, бруцеллёз 27, тэмбүү 10 гаралтаар нэмэгдэж, салхинцэцэг 5, хүйтэн 1, мөөгөнцөр 4, гепатит 583, хамуу 10, гахайн хавдар 9, сүрьеэ 6 гаралтаар тус тус буурч, цусан суулга өвчин өнгөрсөн оны мөн үеийн түвшинд буюу 4 гарсан бол өнгөрсөн оны мөн үед 2 байсан мэнэн өвчин гараагүй байна.

Амбулаториор 328.1 мянган хүнд үзлэг хийгдэж, 19.2 мянган хүн хэвтэн эмчлэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс амбулаториор үйлчлүүлсэн хүнээс 4.5 мянган хүнээр их, хэвтэн эмчлүүлэгчид өнгөрсөн оны мөн үеэс 703 хүнээр цөөн байна.

Хувийн хэвшлийн 12 эмнэлгээр энэ онд нийт 15487 хүн үзлэг, эмчилгээ оношлогоо хийлгэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 149 хүнээр цөөн байна. Мөн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний орлого 141.6 сая төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 71 сая төгрөгөөр буюу 2 дахин өссөн байна.

1.6 БОЛОВСРОЛ

2012-2013 оны мэдээгээр ерөнхий боловсролын 31 сургуулийн 681 бүлэгт 17.9 мянган хүүхэд суралцаж байна. Шинээр 1-р ангийн 68 бүлэгт 1710 хүүхэд элсэн орсон ба өмнөх 3 жилийн дундажтай харьцуулахад 6,8 хувиар буурсан байна. Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоог сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулахад 10,4 хувиар буурсан байна.

Аймгийн ерөнхий боловсролын сургуулиудад 997 багш ажиллаж нэг багшид 18 суралцагч ноогдож байна.

Сургуулийн өмнөх боловсролд 2012 онд 6079 хүүхэд хамрагдаж өмнөх оноос 4.3 хувиар өссөн ба өмнөх 5 жилийн дунджаас 15.2 хувиар өссөн байна.

2012-2013 оны мэдээгээр хөдөлмөрийн дээд сургуулийн 1-р курсэд 69 оюутан элсэн орж нийт 193 оюутан суралцаж байна. Улаангом коллежийн мэргэжлийн боловсролын 1-р курсэд 492 хүүхэд элсэн орж нийт 1350 оюутан суралцаж байна. Техникийн боловсролд 63 хүүхэд шинээр элсэн орсон байна

1.7 СОЁЛ

Аймгийн хөгжимт драмын театр нийт 92.9 мянган хүнд 271 тоглолтоор үйлчилж ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс тоглолтын тоо 13.7 хувиар үзэгчид нь 0.2 хувиар тус тус буурч орлого 0.3 хувиар өссөн байна.

Хөгжимт драмын театрын тоглолтын тоо өмнөх 3 жилийн дунджаас 8 хувиар, үзэгчид 10.6 хувиар тус тус өссөн байна.

Орон нутгийг судлах музей 3.3 мянган хүнд үйлчилж 2,1 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс үзэгчид 13.2 хувиар буурсан бол орлого нь 31.4 хувиар нэмэгдсэн байна. Орон нутгийг судлах музейн орлого өмнөх 3 жилийн дунджаас 40.7 нэмэгдсэн бол үзэгчдийн тоо 6.5 хувиар буурсан байна.

Төв номын сан 4 мянган байнгын уншигч, 35.6 мянган ирэгсдэд 40.6 мянган номоор үйлчилсэн байна. Өмнөх оны мөн үеэс уншигчдын тоо 14.3 хувиар нэмэгдэж, уншуулсан ном 10 хувиар өсчээ.

1.8 ГЭМТ ХЭРЭГ

Цагдаагийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2012 онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 306 болж 2011 оноос 15.7 хувиар, өмнөх 4 жилийн дунджаас 99 гэмт хэргээр буюу 24.4 хувиар тус тус буурсан байна.

Нийт гэмт хэргийн 45.1 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд 44.1 хувь нь Улаангом суманд үйлдэгдсэний дийлэнх хувийг / 37.0 / нь бүх өмчийн хулгайн гэмт хэрэг эзэлж байна.

Гэмт хэргийн гаралт 2011 онтой харьцуулахад Түргэн, Өлгий, Ховд, Хяргас, Цагаанхайрхан, Улаангом сумуудад 27.0 – 89.0 хувиар тус тус буурч, Давст суманд 2.5 дахин, бусад сумуудад 7.7-80.0 хувиар тус тус нэмэгдсэн байна.

2011 онтой харьцуулахад хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 3.2 хувиар өссөн бөгөөд бусдын бие, махбодид гэмтэл учруулсан гэмт хэрэг 2.2 хувиар, бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 3.0 дахин өсч, хүнийг санаатай алах гэмт хэрэг 50.0 хувиар буурсан байна.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 19.3 хувиар, үүний дотроос нийт хулгайн гэмт хэрэг 16.4 хувиар буурсан бөгөөд иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг 47.4 хувиар, малын хулгайн хэрэг 2.5 хувиар, тээврийн хэрэгслийн хулгайн гэмт хэрэг 80.0 хувиар тус тус буурч харин бусад хулгайн гэмт хэрэг 2.8 дахин өссөн байна.

Залилан 28,6 хувиар, өмчлөх эрхийн эсрэг бусад гэмт хэрэг 22.2 хувиар тус тус буурсан байна.

2011 онтой харьцуулахад хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 28.6 хувиар, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 51.4 хувиар, үүнээс танхайн гэмт хэрэг 57.1 хувиар, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 25.0 хувиар, захиргааны журмын эсрэг гэмт хэрэг 83.3 хувиар, шүүн таслах ажиллагааны гэмт хэрэг 66.7 хувиар тус тус буурсан бөгөөд аж ахуйн нэгжийн эсрэг гэмт хэрэг 66.7 хувиар, үүнээс эд зүйлс хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг 33.3 хувиар, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2.7 дахин, тээврийн хэрэгслийн ХАБ, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 4.5 хувиар тус тус өссөн байна.

Энэ онд 289 хүн гэмт хэрэгт холбогдон шалгадсаны 5.9 хувь буюу 17 нь эмэгтэйчүүд, 5.2 хувь буюу 15 нь насанд хүрээгүй хүүхдүүд эзэлж байна. 2011 оноос гэмт хэрэгт холбогдсон хүмүүс 27.0 хувиар, эмэгтэйчүүдийн тоо 41.4 хувиар, насанд хүрээгүй хүүхдүүд 48.3 хувиар тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас иргэд байгууллагад 559.1 сая төгрөгийн хохирол учраад байгаа нь 2011 оноос 12.8 хувиар өссөн байна. Нийт иргэд байгууллагад учруулсан хохирлын 72.0 хувийг нөхөн төлүүлсэн байна. Хохирлын нөхөн төлөлтийг 2011 онтой харьцуулахад 43.6 сая төгрөгөөр буюу 12.1 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн 32.0 хувь нь согтуугаар, 18.6 хувь нь бүлэглэж үйлдэгдсэн бөгөөд өнгөрсөн онтой харьцуулахад согтуугаар үйлдэгдсэн бөгөөд өнгөрсөн онтой харьцуулахад согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 5.4 хувиар өсч, бүлэглэж үйлдэгдсэн гэмт хэрэг 36.0 хувиар буурсан байна.

18-аас дээш насны арван мянган хүнд 70 гэмт хэрэг ногдож өнгөрсөн оноос 14.6 хувиар буурсан бөгөөд Бөхмөрөн /79/, Давст /96/, Зүүнхангай /81/, Малчин /91/, Сагил /97/, Тариалан /74/, Тэс /75/, Улаангом /86/ сумдад аймгийн дунджаас 4.0- 26.0 пунктээр илүү, бусад сумдад аймгийн дунджаасм 11.0 - 63.0 пунктээр бага байна.

Эрүүлжигдсэн хүн 2051 хүн байгаа нь 2011 оноос 409 хүнээр буюу 24.9 хувиар өссөн байна.

Шүүхээр 117 гэмт хэрэгт 182 хүн ял шийтгүүлж, шүүхээр таслуулсан гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 6.4 хувиар, шийтгүүлсэн хүний тоо 9.0 хувиар тус тус буурсан байна. Шүүхээр таслуулсан гэмт хэргийн тоо өмнөх 4 жилийн дунджаас 23.3 хувиар, ял шийтгүүлсэн хүний тоо 22.0 хувиар тус тус буурсан байна.

II. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД :

2.1 Хэрэглээний үнийн индекс

Энэ оноос хэрэглээний үнийн индекс тооцох барааны нэр төрлийг 213 болгож суурь оныг 2010 оны 12 сараар тооцох боллоо. Сар бүрийн 15 - 21 ний байдлаар хүн амын өргөн хэрэглээний 12 бүлэг, сагсны 213 нэрийн барааны үнийн өөрчлөлтийг судалж сарын инфляци тооцож байна. Энэ оны 12-р сарын 15 - 21 нд судлагдаж буй өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф өнгөрсөн оны мөн үеэс 12.7, 2010 оны 12 сар буюу суурь оноос 23.7, өмнөх сараас 1.0 хувиар өссөн байна.

Өмнөх сараасаа хүнсний бараа, согтууруулах бус ундааны барааны бүлгийн үнэ тариф 2.1, согтууруулах ундаа тамхины бүлгийн үнэ 0.3, хувцас бөс барааны бүлгийн үнэ 2.0, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 0.9, амралт чөлөөт цаг соёлын бараа үйчилгээний бүлгийн үнэ 0.5 хувь өсч, бусад бүлгийн үнэ тогтвортой байлаа.

Өмнөх сараасаа 25 бүтээгдэхүүний үнэ 3 - 8000 төгрөгөөр өсч, 4 бүтээгдэхүүний үнэ 17 - 833 төгрөгөөр буурсан байна.

Өмнөх сараасаа гурил 5.9, сүү 36.6, тараг 22.6, хүнсний ногоо 4.3-10 хувь өсч, алим 5, мандарин 14.7 хувиар буурсан байна. Өнгөрсөн оны мөн үеэс мах 33.3 - 44.7 хувиар өссөн байна

Сүүлийн 5 жилийн 12 сарыг оны эхтэй харьцуулсан индексээс харахад 2008 оны 12 сард хамгийн өндөр буюу 24.6 хувийн өсөлттэй байна.

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮУИ) 2012 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 0.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 14.0 хувиар өслөө.Инфляцийн жилийн дундаж түвшин 14.3 хувь байв.

Сүүлийн 5 жилийн 12-р сарыг өмнөх сартайгаа харьцуулсан индексээс харахад 2010 оны 12 сард хамгийн өндөр буюу 4.5 хувийн өсөлттэй, 2008 оны 12 сард хамгийн их буюу 1.5 хувийн бууралттай байсан байна.

2012 он гарсаар 1, 2 дугаар саруудад өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф өмнөх сараасаа 1.5 , 3 дугаар сард өмнөх сараасаа 0.1, 5 дугаар сард өмнөх сараасаа 0.8, 6-р сард өмнөх сараасаа 1.1 , 7- р сард өмнөх сараасаа 1.0 , 8-р сард өмнөх сараасаа 0.7, 9-р сард өмнөх сараасаа 1.1, 10 р сард өмнөх сараасаа 1.0, 11 р сард өмнөх сараасаа 1.2, 12-р сард өмнөх сараасаа 1.0 хувиар өсч, зөвхөн 4 дүгээр сард л 0.1 хувиар буурсан байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулснаар барааны бүлгүүдээр үнийн өөрчлөлтийг тооцож үзвэл :

Үнийн мэдээллийг сайжруулж, өргөжүүлэхийн тулд өргөн хэрэглээний 11 бараа, бүтээгдхүүний үнийг 7 хоног бүрийн 3 дахь өдөр цуглуулж өөрчлөлтийг судалж байна. 2012 оны 12-р сарын 31 ний байдлаар Улаангом хотын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн барааны үнийг дүнгээр нь өмнөх 11 дүгээр сарын дундаж үнэтэй харьцуулахад 5.3 хувь өссөн байна. Өмнөх сарын дундаж үнээс хонины мах 1.9, шингэн сүү 35.3 хувиар өссөн байна.

Махны дундаж үнэ: 2012 оны 12-р сарын 31 ний байдлаар хонины махны үнэ 11-р сарын дундаж үнээс 1.9 хувиар өссөн байна.

12-р сард дунджаар 1 кг хонины мах 5500, үхрийн мах 5500, ямааны мах 3800, 1 л шингэн сүү 1840 төгрөгийн үнэтэй байсан байна.

2.2 МӨНГӨ ЗЭЭЛ

Монгол банкны эх үүсвэрээр 37.2 тэрбум төгрөг зузаатгалаар авч, 327.3 тэрбум төгрөг гүйлгээнд гаргаснаас 351.2 тэрбум төгрөгийг эргүүлэн татаж, татан авалт 107.3 хувьтай байна.

2011 онтой харьцуулахад зузаатгалаар авсан мөнгө 3.0 тэрбум төгрөгөөр буюу 8.6 хувиар, гүйлгээнд гаргасан мөнгө 93.6 тэрбум төгрөг буюу 40.0 хувиар, гүйлгээнээс татсан мөнгө 101.8 тэрбум төгрөг буюу 40.8 хувиар тус тус өссөн байна.

Зээлийн өрийн үлдэгдэл 81.4 тэрбум төгрөгт хүрч, үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 182.0 сая төгрөг болж ноднингийн мөн үеэс бүх зээлийн үлдэгдэл 16.9 тэрбум төгрөгөөр буюу 26.0 хувиар өсч, хугацаа хэтэрсэн зээл 47.7 сая төгрөгийн буюу 21.0 хувиар буурсан байна.

142.2 сая төгрөгийн найдваргүй зээл байгаа нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.2 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 47.4 сая төгрөгөөр буюу 25.0 хувиар буурсан байна.

Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл өмнөх 3 жилийн дунджаас 40.6 тэрбум төгрөгөөр буюу 2.0 хувиар өссөн байна.

Зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээгээр ХААН, Хас банк тэргүүлж байгаа бөгөөд тэдгээрийн зээлийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 83.3 хувьтай тэнцэж байна.

Төрийн банкны нийт зээлийн 0.04, ХААН банк 0.2, Хас банкны 0.2, Хадгаламж банкны 0.16 хувийг хугацаа хэтэрсэн зээл тус тус эзэлж байна.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 44,2 тэрбум төгрөг болж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 36.0 хувиар буюу 11.6 тэрбум төгрөгөөр өсчээ. Сүүлийн 4 жилийн дунджаас иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 24.1 сая төгрөгөөр буюу 2.2 дахин өссөн байна.

Аймгийн 1 хүнд дунджаар 597.4 мянган төгрөгийн хадгаламж ноогдож байгаа өнгөрсөн оноос 160.7 мянган төгрөгөөр буюу 36.8 хувиар өссөн байна.

ЭНЭ ОНД АРИЛЖААНЫ БАНКУУД ИРГЭД, АЖ АХУЙ НЭГЖИД НИЙТ 63.1 МЯНГАН ЗЭЭЛДЭГЧИД 88.0 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ЗЭЭЛИЙГ ОЛГОСОН БӨГӨӨД ТӨРЛӨӨР НЬ АВЧ ҮЗВЭЛ ЛИЗИНГИЙН ЗЭЭЛ 4.3 ХУВЬ, ХАДГАЛАМЖ БАРЬЦААЛСАН ЗЭЭЛ 15.0 ХУВЬ, МАЛЧНЫ ЗЭЭЛ 8.4 ХУВЬ, БИЗНЕСИЙН ЗЭЭЛ 21.3 ХУВЬ, ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛ 4.1 ХУВЬ, ЦАЛИНГИЙН ЗЭЭЛ 23.6 ХУВЬ, ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛ 4.6, ТЭТГЭВЭРИЙН ЗЭЭЛ 13.0, ТӨСЛИЙН ЗЭЭЛ 2.0, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗЭЭЛ 2.3 ХУВИЙГ ТУС ТУС ЭЗЭЛЖ БАЙНА.

2.3 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулан тооцсоноор 2012 онд урьдчилсан гүйцэтгэлээр аймгийн төсөвт аймгийн төсөвт 9,7 тэрбум төгрөг оруулахаас 10,6 тэрбум төгрөгийн орлого орж төлөвлөгөөний биелэлт 109,0 хувьтай, 868,7 сая төгрөгөөр давж биелэгдлээ.

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулалгүйгээр аймаг өөрөө 8,9 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээс 9,4 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 104,9 хувиар биелүүлж 4,9 хувиар буюу 437,4 сая төгрөгөөр давуулсан байна.

Үүнээс улсын төвлөрсөн төсөвт 4,2 тэрбум төгрөгийг татвар, орлогын хэлбэрээр төвлөрүүлэхээс 3,8 тэрбум төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 89,9 хувиар биелүүлж 10,1 хувиар буюу 422,1 сая төгрөгөөр тасалсан байна. Аймгийн төсөвт өөрийн орлогоор 4.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс 5,6 тэрбум төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 118,1 хувиар биелүүлж 18,1 хувиар буюу 859,5 сая төгрөгөөр давууллаа.

Ноднингийн мөн үетэй харьцуулахад аймгийн төвлөрүүлсэн нийт орлого 3,3 хувиар буюу 323,6 сая төгрөгөөр бага, үүнээс улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлсэн орлого 37,7 хувиар буюу 2,3 тэрбум төгрөгөөр бага, аймгийн төсөвт төвлөрүүлсэн орлого 53,7 хувиар буюу 2,0 тэрбум төгрөгөөр илүү байна.

2012 онд улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогуудаас ААНБ-ын орлогын албан татвар 41,0 хувиар, нэмэгдсэн өртгийн албан татварынх 11,7 , агаарын бохирдлын төлбөр 8,5 хувиар тус тус давж биелэгдэн харин онцгой албан татварын төлөвлөгөө 28,3 хувиар, ашигт малтмалын нөөцийн төлбөр 59,2 хувиар тасарлаа.

Энэ онд аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогуудаас орлого тодорхойлох боломжгүй иргэний орлого 4,3 хувиар, ашигт малтмалын нөөцийн төлбөрийн төлөвлөгөө 53,9 хувиар тасарч бусад орлогын төлөвлөгөө 102,8- 326,8 хувиар биелэгдсэн байна.

Өнгөрсөн 2011 оныхоос аймгийн төвлөрсөн төсөвт төвлөрүүлсэн улсын тэмдэгтийн хураамж 39,6 хувиар, агнуурын нөөцийн төлбөр 53,7 хувиар, рашаан ус ашигласны төлбөр 33,3 бага, бусад орлогууд 9,3 – 267,6 хувиар өндөр байна.

Аймгийн төсвийн орлогын 46,8 хувийг тусламжийн орлогоор, 38,6 хувийг орлогын албан татвараар, 4,3 хувийг татварын бус орлогоор, 1,7 хувийг тусгай зориулалтын орлогоор,7,4 хувийг бусад татвар хураамжаар, 1,1 хувийг өмчийн татвараар бүрдүүлсэн байна

Ноднингийн мөн үетэй харьцуулахад тусламжийн орлогын эзлэх хувь 20,3 пунктээр буурч, орлогын албан татварын эзлэх хувь 16 пунктээр өссөн байна.

Аймгийн өөрөө бүрдүүлэх орлогын хэмжээ жил бүр тасралтгүй өсч ирсэн бөгөөд 2012 оны гүйцэтгэлийг сүүлийн 4 жилийн дундажтай харьцуулахад 37,9 хувиар өссөн байна.

2012 онд аймгийн төсвийн нийт зарлагад өөрөө бүрдүүлсэн орлогын эзлэх хувь 16,2 хувь болж 2010, 2011 оны хүрсэн түвшингээс 8,8-13,2 пунктээр багасч, сүүлийн 5 жилийн дунджаас 5,2 пунктээр буурсан байна.

Суурь он буюу 2005 онтой харьцуулахад аймаг өөрөө бүрдүүлсэн орлого 2012 онд 9,2 дахин өндөр, энэ хугацаанд төсвийн зарлага 8,2 дахин өссөн байна.

Төсвийн орлого, зарлагын өсөлт, 2005. I - XII = 100 %

	2007.I- XII / 2005 .I-	2008 I- XII / 2005 I-	2009 .I- XII / 2005.I -XII	2010. I- XII / 2005. I-	2011.I- XII / 2005.I-XII	2012 .I - XII / 2005.I- XII
Орлого	190.7	287.0	405.6	650.4	952.2	920.5
Зарлага	192.9	289.0	309.8	343.5	553.3	826.7

2.4 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Орон нутгийн төсвийн болон улсын төсвийн байгууллагуудын дүнгээр 58,1 тэрбум төгрөгийн зардал гаргасан нь өнгөрсөн оны мөн үеэс 49,4 хувиар их байна. Нийт зарлагын 53,7 хувийг цалин хөлсөнд, 5,7 хувийг эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлд, 5,0 хувийг хөрөнгө оруулалтанд, 7,6 хувийг урсгал шилжүүлэгт, 28,1 хувийг бусад зардалд зориулан зарцууллаа.

Өнгөрсөн оны мөн үеэс цалин хөлсний зардлын эзлэх хувь 0.8 пунктээр өсч, бусад зардлын эзлэх хувь 4.4 пунктээр буурсан байна.

Төсвийн зардлын 24.5 хувийг төрийн үйлчилгээ, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаанд, 41.4 хувийг боловсрол, 19.2 хувийг эрүүл мэндийн салбарт, 3.7 хувийг амралт, спортын үйл ажиллагаанд, 2.3 хувийг ус цаг уур, байгаль орчны үйл ажиллагаанд, 3.0 хувийг бусад үйл ажиллагаанд зориулан зарцууллаа.

Ноднингийн мөн үетэй харьцуулахад төрийн үйлчилгээний салбарт зориулсан зардлын эзлэх хувь 0.4 пунктээр, боловсролын салбарынх 7.7 пунктээр буурч, эрүүл мэндийн салбарт зориулсан зардлын эзлэх хувь 1.0 пунктээр өслөө.

Төсөвт байгууллагуудад 5.0 мянган хүн ажиллаж, ажиллагсадын тоо өнгөрсөн оны мөн үеийнхээс 4.8 пунктээр өссөн байна.

2.5 ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨГЛӨГ, АВЛАГА

Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн байгууллагуудын дүнгээр 2012 оны эцэст 101.6 сая төгрөгийн өртэй, 90.5 сая төгрөгийн авлагатай гарч, өмнөх сараасаа өглөг 389,0 сая төгрөгөөр буурлаа. Өнгөрсөн оны мөн үеэс өглөг 2.9 дахин буюу 66.1 сая төгрөгөөр өсч, авлага 1,2 пунктээр буурсан байна.

12 – р сард 59.1 сая төгрөгийн өр шинээр үүсч, сарын эцэст 252.6 мянган төгрөгийн цалингийн, 1.6 сая төгрөгийн гэрэл цахилгааны, 69.2 сая төгрөгийн түлш, халаалтын, 1.2 сая төгрөгийн цэвэр, бохир усны, 7.3 сая төгрөгийн албан томилолтын, 0.3 сая төгрөгийн эмийн, 14.1 сая төгрөгийн бусад зардлын, 7.6 сая төгрөгийн урсгал засварын өртэй байна.

Төсөвт байгууллагын өглөг сүүлийн 5 жилийн дунджаас 83.8 сая төгрөгөөр буюу 5.7 дахин нэмэгдсэн байна.

Энэ оны 3 - 6 саруудад төсөвт байгууллагуудын өр нилээдгүй нэмэгдэж, ялангуяа 5, 6, 11 саруудад хамгийн өндөр түвшинд хүрсэн байна.

2.6 ГАДААД ХУДАЛДАА

Гаалийн газрын эх сурвалжаар аймгийн гаалийн харъяа хилийн боомтуудаар дамжин нийт 155.7 мянган ам. долларын бараа бүтээгдэхүүнийг экспортолж өнгөрсөн оноос 3854.8 мянган ам.доллараар буюу 96.1 хувиар буурсан байна. Гол нэр төрлөөс 42.7 тн адууны мах, 31 ширхэг монгол гэр, 0.6 тн чулуулгын дээж, 960 метр кватрат эсгийг экспортолж өнгөрсөн оноос гаргасан адууны мах 1055.3 тн-оор буюу 96.1 хувиар, чулуулгын дээж 0.93 тн-оор буюу 60.8 хувиар тус тус буурсан бөгөөд монгол гэр 7.8 дахин өссөн байна.

Нийт импорт 51,2 сая.ам.долларт хүрч өнгөрсөн оноос 2.5 сая.ам.доллараар буюу 5.1 хувиар өссөн байна. 4739 тн гурил, 34.6 мянган тн нефть бүтээгдэхүүн, 10 ш ачааны машин, болон чиргүүл, 1 ш автобус, 1 ш автокран, 74476.9 мян,квт,цаг цахилгаан, 2239 ш мебель тавилга, 635.3 тн овъёс, 47 ш мод хөрөөдөх машин, 2 ш экономайзер, 2 ш циклон батарейный, 155 тн хивэг, 65.9 тн хорголжин тэжээл, 3.4 тн хүнсний бараа, 26.1 тн чихэр, 69.9 тн хөц будаа, 36.1 тн гоймон, 21 тн улаан буудай, 10 тн хүнсний ногоо, 231.6 мянган л чацарганы жүүс, 31.1 тн моторын тос, 10.8 мянган ш аяга, шаазан, 2 ш шингэний нөөцлүүр, 120 $м^3$ банз, 30 ш туузан хөрөөний ир, 7 ш төмөр гангаар хийсэн торх зэргийг тус тус импортоор оруулсан байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад импортоор оруулсан мебель тавилга 33.4 хувиар, цахилгаан 9.0 хувиар, мод хөрөөдөх машин 5.9 дахин, овъёс 44.4 хувиар, авто машин чиргүүл 42.9 хувиар, гурил 11.1 хувиар, дизель түлш 4.6 хувиар, аяга, шаазан 80.0 хувиар, төмөр гангаар хийсэн торх 40.0 хувиар тус тус өсч, харин авто бензин 16.1 хувиар, хивэг 61.4 хувиар, гоймон 75.1 хувиар, хөц будаа 8.0 хувиар, шингэний нөөцлүүр 60.0 хувиар тус тус буурсан байна.

Сүүлийн 4 жилийн дунджаас нийт экспорт 2570.4 мянга ам доллараар буюу 94.3 хувиар буурч, нийт импорт 16.2 сая ам доллараар буюу 46.3 хувиар өссөн байна.

2.7 ДОТООД ХУДАЛДАА

Худалдааны мэдээний түүвэрт сонгогдсон 15 аж ахуйн нэгж байгууллага 27126.9 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллан нэг нэгжийн сарын дундаж орлого 150.7 сая төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 2.5 дахин нэмэгджээ.

Дотоод худалддааны байгууллагын борлуулалтын орлого 2012-4-р улирал /түүврийн нэгжүүдээр/

	Нийт орлого /сая.төг/			Борлуулсан бараа, бүтээгдэхүүний өртөг /сая.төг/			Ажиллагсдын тоо			Эмэгтэй ажиллагсад			түүвэрт хамрагдсан ААНБ тоо		Нэг нэгжийн 1 сарын орлого /сая.төг/	
	2011	2012	Өсөлт бууралтын хувь	2011	2012	Өсөлт бууралтын хувь	2011	2012	Өсөлт бууралтын хувь	2011	2012	Өсөлт бууралтын хувь	2011	2012	2011	2012
Увс	**24953.0**	**27126.9**	**8.7**	**22218.4**	**23935.0**	**7.7**	**243**	**183**	**-24.7**	**109**	**71**	**-34.9**	49	15	42.4	150.7

III. ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

3.1 АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 4.1 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 32.6 хувиар буюу 2.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр 7.7 тэрбум төгрөг болж, өмнөх оныхоос 4.8 тэрбум төгрөгөөр буюу 38.5 хувиар буурсан байна. Нийт үйлдвэрлэлтийн бууралтанд архины үйлдвэрлэлт, мах болон өлөн гэдэс боловсруулах үйлдвэрлэл, нүүрс олборлолтын бууралт түлхүү нөлөөлсөн байна. Архины үнийн өсөлтөөс шалтгаалж худалдан авалт багассан. Үүнээс шалтгаалж архины үйлдвэрлэл 49.3 хувиар, мал махны үнийн өсөлтөөс шалтгаалж мах боловсруулах үйлдвэрлэл 94.4, өлөн боловсруулалт 26.1 хувиар буурссан нь аймгийн аж үйлдвэрийн салбарын бууралтанд нөлөөллөө.

Нийт үйлдвэрлэлтийн 59.3 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 13.3 хувийг эрчим хүч усан хангамж, 27.4 хувийг уул уурхайн салбар эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад аж үйлдвэрийн салбарт эзлэх эрчим хүч түгээлт усан хангамжийн салбар 150 пунктээр, уул уурхай олборлолтын салбар 2.2 пунктээр өсч, боловсруулах үйлдвэр 17,2 пунктээр буурсан байна.

Өнгөрсөн оны мөн үеэс /зэрэгцүүлэх үнээр тооцсоноор/ усан хангамж 16.9 хувиар өсч, боловсруулах үйлдвэрлэл 44.4 хувиар буурч үүний дотор хүнс ундааны үйлдвэрлэл 61.0 хувиар буурч бусад боловсруулах үйлдвэрлэл 15.5 хувиар өслөө. Бусад боловсруулах үйлдвэрээс арьс шир гутлын үйлдвэрлэл 2.5 д, барилгын материалын үйлдвэрлэл 18.4, бусад боловсруулах үйлдвэрлэл 13.0 /морин хуур, эсгий, гэрийн бүрээс, хөшиг, цаваг, хөнжил/, мод модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл 26.8, хувцас үйлдвэрлэл 17,9 хувиар өсч, өлөн боловсруулалт 26.1 хувиар буурсан байна. Хүнс ундааны үйлдвэрлэл дотроо сүүн сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 53.3, хүнсний бусад бүтээгдэхүүний /чацарганы тос, шүүс, даршилсан ногоо, варень/ 31.5 хувиар өсч, гурил гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.3, архи ундааны үйлдвэрлэл 49.3, мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 94.4 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 8.7 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 34.9 хувиар буурсан байна. Нийт борлуулалтын 5.1 хувь буюу 439.4 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд борлуулсан байна.

Аж үйлдвэрийн чиглэлийн 83 аж ахуйн нэгж 61 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний гол нэр төрлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 21 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд өсөлт гарч, 25 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурч, өнгөрсөн оны мөн үед үйлдвэрлэгдэж байгаагүй 16 нэрийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, үйлдвэрлэж байсан 7 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгдээгүй байна.

Гол нэрийн бүтээгдэхүүнээс гутал 4.0 д, өнгөлгөөний тоосго 3.1д, вакум цонх 2.4д, хөх шир 2.0д, чацарганы тос 91.0, дээврийн хавтан 69.1, тараг 52.9, дулаан түгээлт 39.8, модон эдлэл 37.7, гэрийн цагаан бүрээс 34,0, шевро 33.3, эсгийн 26.3, талх 24.3, бялуу 20.6, цэвэр ус түгээлт 16.9, сироп 15.8, пальто 9.1, чацарганы шүүс 8.6, хэрчсэн гурил 2.3 хувиар тус тус өсч, мах боловсруулалт 94.2, цэвэр ус 87.3, варень 84.0, гэрийн хөшиг 73.1, хивэг 65.2, архины үйлдвэрлэл 49.1, ажлын хувцас 48.4, замын хавтан 48.2, гоймон 44.0, нүүрс олборлолт 42.2, эмэгтэй хослол 34.8, хөнжил 33.3, болок 33.3, ундаа 30.3, булигар 29.2, өлөн гэдэс 26.2, морин

хуур 23.3д, дээл тэрлэг 20.3, хиам үйлдвэрлэл 12.1, нарийн боов 7.8, тоосго 4,3 гурил 1.1 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын ажиллагсдын тоо 730 болж өнгөрсөн оны мөн үеэс 3,5 хувиар нэмэгдэж 1 ажиллагчийн хөдөлмөрийн бүтээмж 41.7 хувиар буурлаа.

3.2 БАРИЛГА

Барилгын гүйцэтгэгч 31 аж ахуйн нэгжүүд 18,4 тэрбум төгрөгийн БУИЗ-ын ажил гүйцэтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс /инфляциар засварласанаар/10,3 хувиар буурсан байна. Нийт гүйцэтгэсэн ажлын 85.9 хувийг шинэ барилга, 14.1 хувийг их засварын ажил эзэлж байна. Барилгын салбарын ажиллагсдын тоо 1079 байгаа нь өнгөрсөн оноос 4,6 хувиар өссөн байна. Нийт ажиллагсдын 2,3 хувийг гадаадын иргэд эзэлж байна.

Нийт барилга угсралт их засварын ажлын 11,7 хувь буюу 2.1 тэрбум төгрөгийн ажлыг Улаанбаатар хотын аж ахуйн нэгжүүд, 88.3 хувь буюу 16.3 турбум төгрөгийн ажлыг аймгийн гүйцэтгэгч ААН-үүд гүйцэтгэсэн байна.

Нийт барилга угсралтын ажлын 76.5 хувийг барига объектын ажил, 23.5 хувийг инженерийн барилга байгууламж эзэлж байгаа нь өнгөрсөн оноос барилга объектын ажил 18.1 хувиар, инженерийн барига байгууламжийн ажил 27.3 хувиар буурсан байна.

Ашиглалтанд оруулсан барилга объект /тоогоор/							
	2006	2007	2008	2009	2010	2011	2012
объектын тоо	9	14	23	17	19	32	28

Барилгын гүйцэтгэгч ААН-үүд нийт 5.8 тэрбум төгрөгийн үндсэн фонд бүхий 28 объект ашиглалтанд хүлээлгэн өгсөн байна. Ховд суманд 460.0 сая төгрөгийн ҮФ бүхий ЗДТГ-ын контор, Наранбулаг суманд 546.0 сая төгрөгийн ҮФ бүхий хүн эмнэлэгийн барилга, Түргэн суманд 450.0 сая төгрөгийн ҮФ-той сургуулийн дотуур байр, Улааном суманд 784,4 сая төгрөгийн ҮФ-той ТАХ-ын орон сууц, 900.0 төсөвт өртөгтэй 16 айлын хувийн орон сууц, 599.0 төгрөгийн ҮФ-той соёлын төв, 423.0 төгрөгийн ҮФ –той ШШГА-ны контор, Давст суманд 490.0 сая төгрөгийн ҮФ-той нутгийн удирдлагын ордон зэрэг томоохон барилга объектууд техникийн болон улсын комиссоор хянагдан ашиглалтанд орсон байна.

3.4 ХӨДӨӨ АЖ АХУЙ

3.4.1 Мал аж ахуйн салбар

3.4.1.1 Малын тоо

Аймгийн хэмжээнд мал тооллогын дүнгээр 8.1 мянган малчин өрхийн 16.5 мянган малчид мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Малчин өрхийн тоо өнгөрсөн оноос 558 – аар, малчдын тоо 1281 хүнээр буурсан байна. 1 малчин өрхөд дунджаар 251 толгой мал ноогдож байна.

2012 оны эцэст 2030.7 мянган толгой мал үүний дотор 16.9 мянган тэмээ, 70.4 мянган адуу, 108.0 мянган үхэр, 976.0 мянган хонь, 859.3 мянган ямаатай болж тэмээ 1.5 мянга, адуу 6.5 мянга, үхэр 12.4 мянга, хонь 124.5 мянга, ямаа 54.0 мянган толгойгоор таван төрөлдөө өсч, өнгөрсөн оноос нийт малын тоо 9.8 хувиар буюу 198.9 мянган толгойгоор нэмэгдсэн байна.

Түргэн сумаас бусад сумдын малын тоо өнгөрсөн оноос 2.2 - 21.1 мянган толгойгоор өсч, 9 сум малаа таван төрөл дээрээ өсгөсөн байна.

Сумдыг малын тоогоор бүлэглэвэл:

1. 200.0 мянгаас дээш толгой малтай сумын тоо -1 сум

   Тэс / 246.6 мянган толгой /

2. 100.0 – 150.0 мянган толгой малтай сумын тоо – 9 сум

   Улаангом / 137.6 /, Наранбулаг / 146.9 /, Өндөрхангай /132.0, Хяргас /129.2/, Өмнөговь /127.2/, Сагил /

   108.7 /, Малчин / 116.4/ , Зүүнхангай /106.1/, Цагаанхайрхан / 106.0/,

3. 60.0 -100.0 мянган толгой малтай сумын тоо - 8 сум

   Ховд /97.9/, Бөхмөрөн /90.4/ , Тариалан /90.7/, Түргэн /69.9/, Зүүнговь /78.0 /, Завхан /71.7/, Өлгий /71.3/, Давст /63.8/

4. 50.0 мянга хүртэл малтай сумын тоо – 1 сум Баруунтуруун / 40.1 /

Өнгөрсөн онд 100.0 - 150.0 мянган толгой малтай 7 сум байсан бол одоо 9 болж өсчээ.

Аймгийн нийт малын 12.1 хувийг эзэлж буй Тэс сум 246.6 мянган толгой малтайгаар хамгийн олон малтай, 2.0 хувийг эзэлдэг Баруунтуруун сум 40.1 мянган малтай болж хамгийн цөөн малтайд орж байна.

Мал тооллогын 2012 оны дүнгээр аймгийн хэмжээнд нийт малын тоогоор Тэс сум, Тэмээгээр Завхан сум, мөн адуу, үхэр, хониор Тэс сум, ямаагаар Наранбулаг сум тус тус тэргүүлж байна.

Аймгийн нэг хүнд дунджаар 27 толгой мал ноогдож сумдаар авч үзвэл Улаангом сумын нэг хүнд дунджаар 5, Баруунтуруун суманд 16, Тариалан суманд 24 толгой мал ноогдож байгаа нь аймгийн дунджаас 3 – 22 толгой малаар доогуур, харин бусад сумдад 29 – 54 толгой мал ноогдож байгаа нь аймгийн дунджаас 2 – 27 толгой малаар илүү байна.

Нийт сүрэгт хонь 48.1, ямаа 42.3, үхэр 5.3, адуу 3.5, тэмээ 0.8 хувийг тус тус эзэлж, өнгөрсөн оноос нийт хонины эзлэх хувь 1.6, үхэр 0.1 пунктээр өсч, адуу, тэмээний эзлэх хувь өнгөрсөн оны түвшинд, харин ямааны эзлэх хувь 1.7 пунктээр буурчээ.

Сумдыг бүсчлэн тооцож үзвэл баруун бүсэд нийт малын 29.8 хувь буюу 605.7 мянган мал, зүүн бүсэд 28.1 хувь буюу 570.2 мянган мал, өмнөд бүсэд 18.9 хувь буюу 384.3 мянган мал, хойт бүсэд 16.4 хувь буюу 332.8 мянган мал, төвийн бүсэд 6.8 хувь буюу 137.7 мянган мал тус тус ноогдож байна.

Нийт мал сүргийн 99.4 / 2018.6 мянга / хувь нь амины аж ахуйд, 0.6 хувь нь / 12.1 мянган/ албан газарт ноогдож , амины малын тоо өнгөрсөн оноос 199.0 мянган толгойгоор өссөн байна.

2012 онд 24.4 мянган мал бүхий 304 өрх гадагш шилжсэн бөгөөд үүнээс Тэс сумаас 146 өрхийн 10.1 мянган мал, бусад сумдаас 0.1 – 2.5 мянган мал гадагш шилжсэн байна. Гадагш шилжсэн малын тоо өнгөрсөн оноос 5.2 мянгаар их байна.

3.4.1.2 ХЭЭЛТЭГЧ МАЛ

897.4 мянган хээлтэгч мал тоологдож, хээлтэгчийн тоо өнгөрсөн оноос 11.3 хувь буюу 101.6 мянгаар өссөн байна. Нийт сүргийн 44.2 хувь нь хээлтэгч мал байгаа бөгөөд үүнээс тэмээний 33.0, адууны 28.6, үхрийн 42.5, хонины 46.0, ямааны 43.8 хувь нь хээлтэгч мал эзэлж байна. Хээлтэгч малын тоо Түргэн суманд 7 толгойгоор бусад сумдад 1.1 – 11.3 мянгаар өсчээ.

3.4.1.3 АМИНЫ МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ

100 хүртэлх малтай өрх нийт малтай өрхийн 45.2 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оноос 3.2 пунктээр, 101-200 толгой малтай өрхийн эзлэх хувь өнгөрсөн оноос 0.3 пунктээр багасч, 201-500 толгой малтай өрхийнх 2.2 пунктээр, 501-999 малтай өрхийнх 1.2 пунктээр тус тус өсчээ. 1000 – аас дээш малтай 102 өрх байгаа нь 2011 оныхоос 21 өрхөөр өссөн байна.

Нийт малтай өрхийн 7.2 хувийг 10 хүртэл малтай , 12.2 хувийг 11-30 хүртэл малтай, 9.3 хувийг 31-50 хүртэл малтай, 16.3 хувийг 51-100 хүртэл малтай, 26.4 хувийг 101-200 хүртэл малтай, 23.1 хувийг 201-500 малтай, 5.4 хувийг 501-ээс дээш малтай өрх тус тус эзэлж байна.

Иргэдийн малын бүлэглэлт

	2008	2009	2010	2011	2012
10 хүртэл малтай	845	881	1217	943	883
11-30 малтай	1256	1267	1865	1562	1490
31-50 малтай	1181	1185	1418	1254	1138
51-100 малтай	2324	2151	2416	2166	1991
101-200 малтай	3621	3688	3146	3261	3216
201-500 малтай	3531	3296	2142	2562	2813
501-999 малтай	645	572	316	406	553
1000-1499 малтай	189	136	59	75	95
1500-2000 малтай	8	12	2	3	5
2001-ээс дээш	3	3	4	3	2
Дүн	**13603**	**13191**	**12585**	**12235**	**12186**

Аймгийн нийт өрх 19.8 мянга, үүний 61.4 хувь буюу 12.2 мянган өрх нь мал бүхий байж, эдгээр мал бүхий өрхийн 71.5 хувь нь буюу 8.7 мянган өрх 200 хүртэл малтай өрх байна. Өнгөрсөн оноос 200 хүртэл малтай өрхийн эзлэх хувь 3.6 пунктээр буурсан байна.

200-аас дээш малтай өрхийн эзлэх хувь 23.1 байгаа нь өнгөрсөн оноос 2.2 пунктээр, 500- аас дээш малтай өрхийн эзлэх хувь өмнөх оноос 1.4 пунктээр өссөн байна.

8.1 мянган малчин өрхийн 59 хувь нь 200 хүртэл малтай өрх байна. Тус өрхийн эзлэх хувь өнгөрсөн оноос 7.3 хувиар буурсан байна.

3.4.1.4 Төллөлт, төл бойжилт

Оны эхний эхийн 89.2 хувь буюу 710.2 мянган эх мал төллөж, гарсан төлийн 92.0 хувь буюу 657.1 мянган төл бойжиж байна. Өнгөрсөн онтой харьцуулахад төллөлтийн хувь 10.7 пунктээр, бойжилтын хувь 1 пунктээр буурсан байна. Өнгөрсөн 2010 оноос төлийн хорогдол 11.7 хувиар буюу 7.7 мянгаар буурлаа.

Бөхмөрөн, Тэс, Өндөрхангай, Түргэн, Зүүнхангай сумдын төл бойжилт 73.3 – 89.5 хувь байгаа нь аймгийн дунджаас 2.5 – 18.7 пунктээр бага, бусад сумдын төл бойжилт 90.8 -98.2 хувь байгаа нь аймгийн дунджаас 1.8 – 6.2 пунктээр илүү байна.

100 эх малаас 83 төл үүний дотор 47 ботго, 68 унага , 74 тугал , 87 хурга, 80 ишиг бойжуулсан нь өнгөрсөн оныхоос ботго 6, унага 5, тугал 6, хурга 4, ишиг 17 төлөөр өссөн байна.

3.4.1.5 Том малын зүй бусын хорогдол

Оны эхний малын 2.7 хувь буюу 49.0 мянган толгой мал хорогдсон нь өнгөрсөн оныхоос 0.2 хувь буюу 8.3 мянган толгойгоор өссөн байна.

Нийт хорогдлын 49.0 хувийг хонь, 42.6 хувийг ямаа, 5.0 хувийг үхэр, 3.1 хувийг адуу, 0.3 хувийг тэмээний хорогдол тус тус эзэлж байна.

Өндөрхангай, Түргэн, Тэс, Баруунтуруун, Бөхмөрөн, Зүүнхангай сумдын оны эхний малын 3.7 – 7.6 хувь нь хорогдож аймгийн дунджаас 1.0 – 4.9 пунктээр илүү, бусад сумдын оны эхний малын 0.3 -2.4 пунктээр бага байна.

3.4.2 2012 онд шинээр гаргасан ба засварласан худаг

2012 онд шинээр 32 худаг гаргаж, 12 худаг засварласан ба түүнд нийт 328.7 сая төгрөг зарцуулсны 81.7 хувь нь улсын төсвийн хөрөнгөөр, 6.7 хувь нь гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр, 11.6 хувь нь малчдын хамтын хөрөнгө буюу бусад эх үүсвэрээр санхүүжигдсэн байна.

3.4.3 Малжуулалт

2012 онд малгүй болон мал цөөтэй иргэдийг малжуулах арга хэмжээнд зориулж 98.7 сая төгрөг зарцуулжээ. Малжуулах арга хэмжээ нь орон нутаг гадаад улс орон, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага гэх зэрэг олон төрлийн байгууллагын санхүүжилтээр хийгдэж байна. Аймгийн хэмжээнд 43 өрх малжуулах арга хэмжээнд хамрагдсан бөгөөд нэг өрх

дунджаар 4 ам бүлтэй байна. Нийт 1.8 мянган толгой мал олгосог ба түүний 99.2 хувь нь бог мал, 0.8 хувь нь бод мал байна. Нэг өрхөд дунджаар 43 толгой мал ноогдож байна.

3.5 ГАЗАР ТАРИАЛАН

3.5.1 Тариалалт

8438.2 га-д үр тариа, үүнээс 8229.0 га-д улаан буудай, 276.0 га-д төмс, 208.1 га-д хүнсний ногоо, 681.3 га тэжээлийн ургамал, 370 га-д техникийн ургамал, нийт 9.9 мянган га-д тариалалт хийлээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үр тариа 1220.0 га, төмс 41.6 га, хүнсний ногоо 32.6 га, тэжээлийн ургамал 71.7 га-аар тус тус өсчээ.

Баруун туруун сум 7424 га, Тариалан сум 685 га, Сагил сум 150 га-д үр тариа тариалсан нь аймгийн нийт тариалсан үр тарианы 97.9 хувийг эзэлж байна. Тариалан, Баруунтуруун, Улаангом сумдад 388.5 га-д төмс, хүнсний ногоо тариалсан нь төмс, хүнсний ногоо тариалалтын 80.3 хувийг эзэлж байна.

Хавар тариалсан нийт үр тарианы 77.7 хувийг аж ахуйн нэгж байгууллага, харин төмс, хүнсний ногооны 74.0 хувийг иргэд тариалсан байна.

3.5.2 Ургац хураалт

Аймгийн хэмжээнд 7574.4 тн үр тариа, үүнээс 7250.0 тн улаан буудай, 3100.9 тн төмс, 2591,7 тн хүнсний ногоо, 967.4 тн тэжээлийн ургамал хураан авсан байна.

Хураан авсан үр тарианы 18.5, төмсний 65.4, хүнсний ногооны 74.9 хувийг иргэд хураан авсан байна.

Хураан авсан үр тарианы 97.5 хувь нь Баруунтуруун, Тариалан, Сагил сумдад, төмсний 85.1 хувь нь Улаангом, Баруунтуруун, Тариалан, Наранбулаг сумдад, хүнсний ногооны 85.3 хувь нь Улаангом, Баруунтуруун, Тариалан сумдад тус тус ноогдож байна.

50.5 мянган тн хадлан өвс, 2320 тн гар тэжээл бэлтгэх төлөвлөгөөтэйгээс 51.5 мянган тн байгалын хадлан, 1937 тн гар тэжээл бэлтгэж, хадлангын төлөвлөгөөг 1.9 хувиар давуулан биелүүлж, гар тэжээл бэлтгэлтийн төлөвлөгөө 16.5 хувиар тасарсан байна.

51.5 мянган тн байгалийн хадлан бэлтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 1.6 мян.т-оор буурсан байна.

3.5.3 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дундаж үнэ

Малын үнэ: 2012 оны 12-р сарын 28-ны байдлаар тус аймагт ботгоноос бусад насны тэмээний үнэ 883.3 – 1250.0 мянга, унага ба бүх насны адууны үнэ 135.0 – 1066.7 мянга, тугал ба бүх насны үхрийн үнэ 100.0 – 850.0 мянга, хурга ба бүх насны хонины үнэ 41.6 – 155.0 мянга, ишиг ба бүх насны ямааны үнэ 26.7 – 125.0 мянган төгрөгний дундаж үнэтэй байна.

Өмнөх сартай харьцуулахад ингэ, гүү, шарын үнэ 5.7 – 83.3 мянгаар буурч, бусад малын үнэ 0.3 – 35.7 мянган төгрөгөөр тус тус өсчээ.

Арилжаалагдаж байгаа бүх малын үнэ өнгөрсөн оны 12 сарын 28-ны байдлаас 27.5-93.9 хувиар өссөн байна. Үүний дотор азрага 93.9, эм хонь 86.3, үнээ 85.1, буур 78.6, ат 72.6, ингэ 65.1, морь 52.1, гүү 45.2, шар 50.9, үнээ 85.1, эр хонь 60.3, эм хонь 86.3, эр эм төлөг 67.7, хурга 42.9, ухна 78.6, эр ямаа 45.4, эм ямаа 27.5, эр ба эм борлон 33.3, ишиг 46.1 хувиар өссөн байна.

ХАА-н зарим бүтээгдэхүүн:

Гол нэрийн бүтээгдэхүүн болох тэмээний шир 10000, адууны шир 28000, үхрийн шир 23500, хонины арьс 13000, ямааны арьс 20000, тэмээний мах 4500, зөгийн бал 20000, өндөг 300 төгрөгний дундаж үнэтэй байна.

Өмнөх оны мөн үеэс адууны шир 20 хувиар, хонины арьс 3.7 хувиар буурч, ямааны арьс 2.6, үхрийн шир 6.8 хувиар өссөн байна.

Газар тариалан болон бусад бүтээгдэхүүн:

Задгай өвс тн нь 82.5 мянга, хужир шүү тн нь 30.0 мянга, боодолтой өвс ширхэг нь 4100, чацаргана кг нь 4125, үхрийн нүд кг нь 6000, сонгино кг нь 3000, аргал 27.0 мянга, хөрзөн тн нь 35.0 мянга, түлээний мод м.куб нь 29.8 мянган төгрөгийн дундаж үнэтэй байна.

Өмнөх сартай харьцуулахад задгай өвсний үнэ 29.3 хувиар, түлээний мод 7.2 хувиар, чацаргана 2.9 хувиар буурч өргөст хэмх 2.9 хувиар өссөн байна.

3.6 ТЭЭВЭР ХОЛБОО

Зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэд 44.3 мянган зорчигч тээвэрлэж 18240.8 мян.хүн.км-ийн зорчигч эргэлт хийснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зорчигчдын тоо 69.6 хувиар, зорчигч эргэлт нь 36.2 хувиар тус тус буурсан байна.

Ачаа тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэд 48.5 мян.тн ачаа тээвэрлэж 14778.5 мян.тн.км-ийн ачаа эргэлт хийснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тээсэн ачаа нь 62.2 ачаа эргэлт нь 54.3 хувиар буурсан байна.

Холбооны үйл ажиллагаа эрхэлж, мэдээнд хамрагддаг аж ахуйн нэгж газрууд 368.9 сая төгрөгийн орлоготой ажилласны 41.2 хувь нь хүн амаас орсон ба өнгөрсөн оны мөн үеэс нийт орлого нь 4.3 хувиар буюу 16.4 сая төгрөгөөр буурсан байна.

Холбооны газраар үйлчлүүлсэн цахилгаан мэдээний тоо 30 хувь буурч, бичиг, захидал, боодол хүргүүлэх үйлчилгээ 69.5 хувиар нэмэгдсэн байна.

Аймгийн бүх сумдад үүрэн телефоны операторууд үйл ажиллагаа явуулж байгаа ба тэдний хэрэглэгчдийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 15,0 хувиар өссөн байна.

3.7 ЦАГ УУРЫН БАЙДАЛ

2012 оны 12-р сард агаарын дундаж температур Улаангом, Малчин, Тэс, Баруунтуруун, Зүүнговьд -26.9 хэмээс -30.2 хэм хүйтэн, хөрсний дундаж температур Тэс, Баруутуруун, Зүүнговь, Түргэнд -29.0 хэмээс -31.0 хэм хүйтэн байлаа.

